МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСЫН ХООРОНД ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэх/, хоёр орны хооронд цаашдын пайрсаг харилцааг хөгжүүлэх хүсэл зоригийг удирдлага болгон, гүүнчлэн эрх зүйн туслалцааны болон эрх зүйн харилцааны хүрээнд харилцан хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх хийгээд боловсронгуй болгохыг эрмэлзэн,

доорх зүйлийг хэлэлцэн тохиров.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл Эрх зүйн хамгаалалт

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр хувийн болон эд хөрөнгийн талаар Хэлэлцэн тохирогч энэ Талын иргэний нэгэн адил эрх зүйн хамгаалалт эдэлнэ. Энэ нь Хэлэлцэн тохирогч нэг Талын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүх, прокурор, нотариатын байгууллага (цаашид "хуулийн байгууллага" гэх) болон эрүүгийн хэргийг авч хэлэлцэх эрх бүхий байгууллагад чөлөөтэй, саадгүй хандах эрхтэй бөгөөд тэдгээрт өргөдөл гаргах, түүнчлэн байцаан шийтгэх ажиллагаанд Хэлэлцэн тохирогч энэ Талын иргэний нэгэн адил нөхцөлөөр оролцох эрхтэй.

Хоёрдугаар зүйл Эрх зүйн туслалцаа үзүүлэх

1. Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн байгууллагууд энэхүү гэрээний дагуу эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааг харилцан үзүүлнэ.

2. Хуулийн байгууллагууд эрүүгийн хэрэгт хамаарах бусад байгууллагад эрх зүйн туслалцааг үзүүлнэ. Эрүүгийн хэрэгт хамаарах бусад байгууллагууд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг хуулийн байгууллагаар дамжуулан хүргүүлнэ.

Гуравдугаар зүйл Эрх зүйн туслалцааны хэмжээ

Эрх зүйн туслалцаа нь Хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу байцаан шийтгэх ажиллагааг явуулах мөн яллагдагч, шүүгдэгч, гэрч, шинжээч нарыг

байцаах, шүүхийн эл мөрийн баримт шинжүүлэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах, шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, бичиг баримтыг гардуулах, илгээх, иогөө Талын хүсэлтээр ялтан этгээдийн ял шийтгэлийн талаарх мэдээлэл өгөх явдлыг хамарна.

Дөрөвдүгээр зүйл
Харилцах журам

Эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ Хэлэлцэн тохирогч Талуудын байгууллага нь Монгол Улсын Хууль зүйн яам, Улсын Ерөнхий прокурорын газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Хууль зүйн яам, Ерөнхий Прокурорын газар болон Шүүхийн Ерөнхий газраар дамжуулан харилцана.

Тавдугаар зүйл
Харилцах хэл

Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг Хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хэл дээр буюу хэрэв энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол орос хэл дээр үйлдэнэ.

Зургадугаар зүйл
Бичиг баримтыг бүрдүүлэх

Хуулийн байгууллага буюу бусад байгууллагаас ирүүлсэн эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон бичиг баримтыг тэмдэг дарж баталгаажуулна.

Долдугаар зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварын хэлбэр

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар дараах зүйлийг агуулна:

1/ хүсэлт гаргасан байгууллагын нэр;
2/ хүсэлт хүлээн авсан байгууллагын нэр;
3/ эрх зүйн туслалцаа үзүүлэхийг хүссэн хэргийн нэр;
4/ яллагдагч, шүүгдэгч буюу ялтан этгээдийн овог, нэр, түүний байнга буюу түр оршин суугаа газар, иргэний харьяалал;
5/ дээрх этгээдүүдийг төлөөлөх хүмүүсийн овог, нэр, хаяг;
6/ даалгаварын гол утга болон эрүүгийн хэргийн талаар, түүнчлэн үйлдэглэсэн гэмт хэргийн тухайд нэмэлт тодорхойолт, түүний хуулийн зүйлчлэл.

Наймдугаар зүйл
Гүйцэтгэх журам

1. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварыг биелүүлэхэл даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага өөрийн орны хууль тогтоомжийг хэрэглэнэ. Хэрэв өөрийн орны хууль тогтоомжил харшлахгүй бол даалгавар хүлээн авсан байгууллага даалгавар өгсөн Хэлэлцэн

тохирогч Талын байцаан шийтгэх хэм хэмжээг түүний байгууллагын хүсэлтээр хэрэглэж болно.

2. Хэрэв даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага нь түүнийг биелүүлэх эрх бүхий биш бол тэрээр уг даалгаварыг эрх бүхий хуулийн байгууллагад шилжүүлэх бөгөөд даалгавар өгсөн байгууллагад мэдэгдэнэ.

3. Даалгавар биелүүлсэний дараа даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага даалгавар өгсөн байгууллагад баримт бичгийг хүргүүлэх бөгөөд хэрэв эрх зүйн туслалцааг үзүүлж чадаагүй бол биелүүлэхэд саад болсон шалтгааныг заажг даалгаварыг буцаан хүргүүлнэ.

Есдүгээр зүйл
Бичиг баримтыг гардуулах

1. Хэрэв гардуулбал зохих баримт бичиг нь Хүсэлт хүлээн авсан Талын хэл дээр буюу баталгаат орчуулгаар хангагдсан бол тэрээр өөрийн улсад үйлчилдэг журмын дагуу баримт бичгийг гардуулна. Хэрэв баримт бичиг нь Хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хэл дээр үйлдэгдээгүй эсвэл баталгаат орчуулгаар хангагдаагүй нөхцөлд хүлээн авагч нь түүнийг хүлээн авахаа зөвшөөрсөн тохиолдолд гардуулан өгнө.

2. Гардуулбал зохих баримт бичигт хүлээн авагчийн зөв хаяг ба гардуулан өгөх баримт бичгийн нэрийг тусгасан байна. Хэрэв гардуулбал зохих баримт бичигт дурдсан хаяг нь бүрэн бүтэн биш бөгөөд тодорхой бус байвал Хүсэлт хүлээн авсан Тал өөрийн хууль тогтоомжийн дагуу зөв хаягийг тодруулах арга хэмжээ авна.

3. Баримт бичгийг гардуулсан тухай нотолгоог хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр үйлчилж буй дүрмийн дагуу бүрдүүлнэ. Нотолгоонд гардуулсан тухай цаг хугацаа, газрыг мөн баримт бичиг хүлээн авсан этгээдийг заана.

Аравдугаар зүйл
Дипломат төлөөлөгчийн буюу консулын газраар дамжуулан баримт бичгийг гардуулах буюу иргэдийг байцаах

Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн дипломат төлөөлөгчийн буюу консулын газраар дамжуулан баримт бичгийг гардуулах буюу өөрийн иргэнийг байцаах эрхтэй. Ингэхдээ албадлагын шинжтэй арга хэмжээ авч болохгүй.

Арван нэгдүгээр зүйл
Гэрч буюу шинжээчийг хилийн чанадад дуудах

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэр дээр урьдчилсан мөрдөн байцаалт явуулах буюу шүүхээр хэргийг хянан шийдвэрлэхэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа гэрч буюу шинжээчийг дуудах шаардлага гарвал зарлан дуудах хуудас гардуулах тухай даалгаварын хамт Хэлэлцэн тохирогч энэ Талын холбогдох байгууллагад хандаж болно.

2. Дуудлагаж буй этгээдийг ирээгүй тохиолдолд арга хэмжээ авах талаар зарлан дуудах хуудаст тусгасан байж болохгүй.

3. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын холбогдох байгуллагын дуудлагаар сайн дураар хүрэлцэн ирсэн гэрч буюу шинжээчийг аль улсын харьяат болохыг үл харгалзан гаргасан мэдүүлэг буюу шинжээчийн дүгнэлт эсвэл мөрдөгдөж байгаа хэрэгтэй холбогдох үйлдэлтэй нь холбогдуулан энэхүү Харилцан тохирогч Талын нутаг дэвсгэр дээр эрүүгийн хариуцлагад татах, цагдан хорих буюу ял шийтгэл хүлээлгэж болохгүй.

4. Гэрч буюу шинжээч нь даалгавар өгсөн байгууллагаас цаашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэнээс хойш даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс 15 хоногийн дотор гарч явааагүй бол энэхүү эрх ямбыг здлэхгүй. Энэхүү хугацаанд гэрч буюу шинжээч нь даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс өөрөөс нь үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас гарч явж чадаагүй хугацааг оруулан тооцохгүй.

5. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт дуудагдаж ирсэн гэрч буюу шинжээч нь хил нэвтрэх болон хилийн чанадад байх зардал, мөн ажлаасаа хөндийрсний улмаас ажиллаагүй өдрийн цалингаа нөхөж төлүүлэх, түүнчлэн гэрч буюу шинжээчээр ажилласныхаа шагналыг авах эрхтэй. Дуудагдаж буй иргэн ямар зардал авах эрхтэйг зарлан дуудах хуудаст заасан байх ёстой, мөн түүний хүсэлтээр дуудлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал холбогдох зардлыг нөхөхөл зорилуулж урьчилгаа олгоно.

Арван хоёрдугаар зүйл
Баримт бичгийг хүлээн зөвшөөрох

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүх буюу эрх бүхий этгээдийн / байгын орчуулагч, шинжээч болон бусад/ өөрийн эрх хэмжээний хүрээнд, тогтоосон хэлбэрийн дагуу үйлдсэн буюу баталгаажуулж, тэмдэг дарж нотолгоожуулсан баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр ямар нэгэн нотолгоогүйгээр хүлээн зөвшөөрнө.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэр дээр албан ёсны гэж тооцогдоог баримт бичиг нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэгэн адил албан ёсны гэж хүлээн зөвшөөрөгдөнө.

Арван гуравдугаар зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэх зардал

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн нутаг дэвсгэр дээр эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон гарсан зардлыг хариуцна.

2. Хүсэлт хүлээн авсан Тал Хүсэлт гаргасан Талд гарсан зардлын хэмжээг мэдэгдэнэ. Хэрэв хүсэлт гаргасан Тал уг зардлыг төлөх үүрэг бүхий этгээдээс гаргуулж авсан бол тэр нь зардлыг гаргуулсан Хэлэлцэн тохирогч Талын орлого болно.

Арван дөрөвдүгээр зүйл
Мэдээлэл өгөх

Хэлэлцэн тохирогч Талуудын төв байгууллагууд өөрийн оронд дагаж мөрдөж байгаа, эсхүл дагаж мөрдөж байсан хууль тогтоомжийн тухай болон түүнийг хуудийн байгууллагууд хэрэглэж буй асуудлаархи мэдээллийг хүсэлтийн дагуу харилцан бие биендээ өгч байна.

Арван тавдугаар зүйл
Эд зүйл болон мөнгө шилжүүлэх

Хэрэв энэхүү Гэрээг биелүүлэхэд Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт, мөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт эд зүйл болон мөнгө шилжүүлбэл шилжүүлж буй байгууллагын Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ. Хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч талаас хүргүүлсэн эд зүйлийн хувьд гуравдагч этгээдийн эрх хүчинтэй хэвээр байна. Байцаан шийтгэх ажиллагаа дууссаны дараа уг зүйлийг хүргүүлсэн Хэлэлцэн тохирогч Талд буцаах ёстой.

Арван зургаадугаар зүйл
Хаяг болон бусад мэдээг тогтоох

Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн байгууллагууд эрх зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд хүссэний дагуу өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа этгээдийн хаягийг тогтооход дэмжлэг үзүүлнэ.

Арван долдугаар зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах

Хэрэв эрх зүйн туслалцаа үзүүлэх нь Хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын тусгаар тогтнол, аюулгүй байдал, болон хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшлахаар бол эрх зүйн туслалцааг үзүүлэхээс татгалзаж болно.

ХОЁРДУГААР ХЭСЭГ
ТУСГАЙ ЗААЛТ

Арван наймдугаар зүйл
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа өөрийн иргэний хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хүсэлтээр хууль тогтоомжийнхоо дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг хүлээнэ.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын хуулийн дагуу хохирогчоос түүний эрх бүхий байгууллагад хохирол хугацаанд гаргасан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тухай өргөдөл нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт адил хүчинтэй байна.

3. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай шаардлагыг Монголын талаас Монгол улсын ерөнхий прокурор, Киргизийн талаас Бүгд Найрамдах Киргиз Улсын ерөнхий прокурор гаргана.

4. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үр дүнгийн талаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талд мэдэгдэнэ. Хэрэв таслан шийдвэрлэх тогтоол гаралт хүчин төгөлдөр болсон бол түүний хуулбарыг хүргүүлнэ.

Арван есдүгээр зүйл
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлт

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлтийг бичгээр гаргаж дараахь зүйлийг агуулсан байна:

1/ хүсэлт гаргасан байгууллагын нэр;
2/ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлттэй холбогдсон үйлдлийн тодорхойлолт;
3/ үйлдэл нь гарсан цаг хугацаа, газрыг аль болох тодорхой заасан мэдээлэл;
4/ үйлдэл нь гэмт хэрэг гэж тооцогдох үндэслэл бүхий Хэлэлцэн Тохирогч талын хуулийн заалт;
5/ сэжиглэгдэж буй этгээдийн овог нэр, иргэний харьяалал, оршин суугаа буюу оршин байгаа газар, уг хүний талаарх аль болох дэлгэрэнгүй мэдээ, түүнчлэн хэрэв боломжтой бол уг этгээдийн гаднах байдал, түүний гэрэл зураг, хуруугны хээ;
6/ хохирогчийн гомдлоор үүссэн эрүүгийн хэргийн талаархи хохирогчийн өргөдөл, хэрэв байгаа бол эд хөрөнгийн хохирол нөхөн төлүүлэх тухай өргөдөл;
7/ хохирлын хэмжээний талаарх мэдээлэл.

Хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч Талын мэдэлд байгаа урьдчилан мөрдөн байцаалтын материал болон нотлох баримтыг хүсэлтэд хавсаргана. Гэмт хэргийн зэвсэг болсон буюу ийм гэмт хэргийн үр дүнд олж авсан эд зүйлийг шилжүүлэхдээ 15 дугаар зүйлийн 2 дахь заалтыг харгалзан үзэх хэрэгтэй.

2. Хэрэв энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлтийг илгээх үед ийм байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай Хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч Талд уг этгээд цагдан, хоригдож байгаа бол хэлэлцэн тохирогч нөгөө Талд хүргүүлнэ. Цагдан хоригдож байгаа этгээдийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд харгалзан хүргэх шийдвэрийг хэргийг мөрдөж байгаа эрх бүхий этгээд гаргана. Хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлэн өгөхтэй холбогдсон өөрийн шийдвэрийг шилжүүлэн өгөх газар, цаг хугацааны хамт мэдээлнэ.

Хорьдугаар зүйл
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үр дүнгийн тухай мэдээлэх

Хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал хэргийн талаархи эцсийн шийдвэрээ Хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдээлнэ. Энэхүү шийдвэрийн хуулбарыг Хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хүсэлтээр хүргүүлнэ.

Хорин нэгдүгээр зүйл
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулсны үр дагавар

Хэрэв Хүсэлт хүлээн авсан байгууллага нь хэргийг үүсгэх буюу дуусгавар болгохоос татгалзаж буй тухайгаа Хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдсэн тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлтдээ хэргийг сэргээж болох тухай дурдаагүй бол Хүсэлт өгсөн Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага нь тухайн хэрэгт тухайн этгээдийн хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулсны дараа байцаан шийтгэх ажиллагааг явуулж болохгүй.

ГУРАВДУГААР ХЭСЭГ
ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

Хорин хоёрдугаар зүйл

1. Энэхүү Гэрээ нь Хэлэлцэн тохирогч Талуудын байгуулсан бусад олон улсын гэрээнээс үүсэн гарах тэдний эрх, үүргийг хөндөхгүй.

2. Энэхүү Гэрээний заалтуудыг тайлбарлах болон хэрэглэхтэй холбогдож маргаан гарвал түүнийг харилцан зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

3. Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичгийг солилцсон өдрөөс хүчин төгөлдөр болно.

4. Энэхүү Гэрээг 5 жилийн хугацаатай байгуулав. Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Гэрээний тухайн хугацаа дуусахаас 6 сарын омнө Гэрээг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд бичгээр мэдэгдээгүй бол энэ Гэрээ дараа дараагийн 5 жил тутам аяндаа сунгагдана.

Энэхүү Гэрээг 1999 оны 12 сарын 14-ны өдөр Бишкек хотноо монгол, киргиз, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Энэхүү Гэрээг тайлбарлах явцад санал зөрөлдвөл Хэлэлцэн тохирогч Талууд орос хэл дээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ